

ӨРИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ТУХАЙ
БОЛОН
ОДООГИЙН ҮЛДЭГДЭЛ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ БАТЛАМЖ
(“Батламж”)

ХЭНД: ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК (“ЭОТ”)

ХУВИЙГ: (дор тодорхойлсон) НӨОДТХНГ-НИЙ ТАЛ ТУС БҮРТ

ХЭНЭЭС: ОЮУ ТОЛГОЙ НИДЕРЛАНД БИ.ВИ. (“ОТН”)

ЭОТ, ТиЭйчАр Оюу Толгой (БиВиАй) Лтд (хуучин нэрээр Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лтд) (“**ТиЭйчАр ОТ**”) ОТН болон Оюу Толгой ХХК (хуучин нэрээр Айвенхоу Майнз Монголия Инк ХХК) (“**ОТ ХХК**”) нарын хооронд 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр байгуулагдсан Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ (“**НӨОДТХНГ**”),

Энэхүү Батламжийг үйлдсэн өдөр ОТН болон ТиЭйчАр ОТ нарын үйлдсэн Албан ёсны мэдэгдэл (“**Албан ёсны мэдэгдэл**”)–ийг тус тус удирдлага болгов.

Энэхүү Батламжид том үсгээр тодотгож хэрэглэсэн нэр томъёог тухайн зүйл заалтад өөрөөр заагаагүй тохиолдолд НӨОДТХНГ-нд тодорхойлсон утгаар ойлгоно.

ОГНОО: Энэхүү Батламжийн огноо нь дор тодорхойлсон Хүчин төгөлдөр болох өдөр байна.

АГУУЛГА: НӨОДТХНГ-нд заасны дагуу үүссэн одоогийн Үлдэгдэл төлбөрийн хувьд ОТН нь эрхээсээ татгалзсаны дагуу ЭОТ-н өр төлбөрийн үүрэг бүрэн төлөгдсөнийг батлах тухай (“**Өр төлбөрийн үүрэг**”)

Хүндэт танаа,

1. (i) Албан ёсны мэдэгдэл болон (ii) ОТН-аас ЭОТ-н нэрийн өмнөөс ОТ ХХК-д өгсөн Санхүүжүүлсэн дүнг баталгаажуулан ОТ ХХК-аас ОТН-д гаргаж өгсөн бөгөөд энд хавсаргасан Хавсралт 1 дах хүснэгтээр Санхүүжүүлсэн дүнгийн хамт нарийвчлан заасан зээлийн гэрчилгээнүүд (“**Зээлийн гэрчилгээ**”)–ийг энд удирдлага болгов.
2. Монгол Улсын Иргэний хууль (2002)-ийн 236.6 болон 239.1 дүгээр заалтууд болон зээлдэгч ЭОТ болон зээлдүүлэгч ОТН нарын харилцан хэлэлцэн тохиролцсоныг тус тус үндэслэн

Албан ёсны мэдэгдэлд тодорхойлсон Хүчин төгөлдөр болох өдрийг оролцуулан тухайн өдөр (“**Хүчин төгөлдөр болох өдөр**”)–өөс эхлээд ОТН нь Албан ёсны мэдэгдлийн хүрээнд Өр төлбөрийн үүрэгтэй холбоотой аливаа болон бүхий л төлбөрийн үүргээс чөлөөлж буйг бид үүгээр та бүхэнд мэдэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор Хүчин төгөлдөр болох өдрийн байдлаар дараах батламжийг бид гаргаж байна. Үүнд:



TURQUOISE HILL

- (i) Монгол Улсын Иргэний хуулийн 239.1 дүгээр заалтын дагуу ОТН-ийн зүгээс бүхэлд нь чөлөөлсний дагуу Хүчин төгөлдөр болох өдрийн байдлаар дор дэлгэрэнгүй тусгасан ЭОТ Өр төлбөрийн үүргээ бүрэн биелүүлсэнд тооцно:

Өр төлбөрийн үүргийн төрөл:	ОТ ХХК-ийн ЭОТ-д гаргасан энгийн хувьцаатай холбоотойгоор ЭОТ-оос ОТ ХХК-д оруулах хувь нийлүүлсэн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор НӨОДТХНГ-ий дагуу олгосон зээл
-----------------------------	--

Өр төлбөрийн дүн (үндсэн дүн, хүү эсхүл Санхүүжүүлсэн дүнтэй холбоотой төлөх ёстой бусад бүхий л төлбөрийг оролцуулаад)	2,363,002,090 ам.доллар
---	-------------------------

Зээлдэгчийн бүтэн нэр	Эрдэнэс Оюу Толгой ХХК
-----------------------	------------------------

Өр төлбөрийн үүргийг гүйцэтгэх газар	Монгол Улс, Улаанбаатар хот
--------------------------------------	-----------------------------

Өр төлбөрийн үүргийг гүйцэтгэх хугацаа	Хүчин төгөлдөр болох өдөр
--	---------------------------

- (ii) ОТН нь дээрх (i)-д заасан Өр төлбөрийн үүрэгтэй холбоотойгоор ЭОТ-н төлөх ёстой аливаа болон бүхий л дүнгийн буцаан төлөх үүргээс ЭОТ-г чөлөөлсөн болно.

3. Хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн НӨОДТХНГ-нд тодорхойлсон Үлдэгдэл төлбөр ТЭГ болно.
4. Энэхүү Батламжид дурдсан аливаа зүйлс нь (i) ЭОТ-н нэрийн өмнөөс АйВиЭн-ийн Санхүүжүүлэгчийн зүгээс ОТ ХХК-д ирээдүйд олгох боломжит Санхүүжүүлсэн дүн болон Хүчин төгөлдөр болох өдрөөс хойш үүсэх шинэ Үлдэгдэл төлбөрийн үр дагаварт нөлөөлөхгүй, ба (ii) НӨОДТХНГ-нд нэмэлт өөрчлөлт оруулсанд тооцогдохгүй.
5. Энэхүү Батламжийг хүлээн авмагцаа хүлээн зөвшөөрсөн хэсэгт гарын үсэг зуран, баталгаажуулсан хувиа Төлөөлөн Удирдах Зөвлөлд хаяглан Кингсфордвэг 151, 02.02 байр, 1043 ЖиАр, Амстердам, Нидерланд хаягаар бидэнд, хувийг Компанийн нарийн бичгийн даргад хаяглан 3680 дугаар байр, 1 Плас Вилл Мари, Монреаль, Кебек, Канад Улс хаягаар Туркойз Хилл Ресурсес Лтд компанид ирүүлэхийг хүсэж байна.
6. Энэхүү Батламжийг Монгол Улсын хуулийн дагуу үйлдэж, тайлбарлана.
7. Энэхүү Батламжийг Монгол ба Англи хэл дээр хүргүүлэх ба Монгол ба Англи хэл дээрх хувилбар нь адил хүчинтэй боловч Монгол ба Англи хэл дээрх хувилбарын хооронд аливаа зөрүү гарах тохиолдолд Англи хэл дээрх хувилбарыг баримтална.

Хүндэтгэсэн,

Оюу Толгой Нидерланд Би.Ви.-ийн нэрийн өмнөөс



**ӨРИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ТУХАЙ
БОЛОН
ОДООГИЙН ҮЛДЭГДЭЛ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ БАТЛАМЖ
("Батламж")**

Зээлийн гэрчилгээнүүд, тэдгээрийн дагуу Санхүүжүүлсэн дүнгийн хүснэгт

Зээлийн гэрчилгээ (аливаа нэмэлт өөрчлөлтийн хамт)	Санхүүжилтийн өдөр	Санхүүжүүлсэн дүн
Зээлийн гэрчилгээ №1	2011 оны 10 сарын 28	139,134,556
Зээлийн гэрчилгээ №2	2011 оны 11 сарын 28	90,185,099
Зээлийн гэрчилгээ №3	2012 оны 4 сарын 2	118,969,862
Зээлийн гэрчилгээ №4	2012 оны 4 сарын 30	67,198,306
Зээлийн гэрчилгээ №5	2012 оны 6 сарын 7	115,082,967
Зээлийн гэрчилгээ №6	2011 оны 1 сарын 31	701,673,412
Зээлийн гэрчилгээ №7	2012 оны 11 сарын 5	62,932,374
Зээлийн гэрчилгээ №8	2012 оны 11 сарын 19	65,413,370
Зээлийн гэрчилгээ №9	2013 оны 6 сарын 24	12,704,773
Зээлийн гэрчилгээ №10	2013 оны 7 сарын 2	19,029,158
Зээлийн гэрчилгээ №11	2013 оны 7 сарын 8	19,008,753
Зээлийн гэрчилгээ №12	2013 оны 7 сарын 15	25,312,809
Зээлийн гэрчилгээ №13	2013 оны 7 сарын 22	25,280,684
Зээлийн гэрчилгээ №14	2013 оны 7 сарын 29	12,624,324
Зээлийн гэрчилгээ №15	2013 оны 8 сарын 5	27,112,769
Зээлийн гэрчилгээ №16	2013 оны 8 сарын 19	35,848,715
Зээлийн гэрчилгээ №17	2013 оны 8 сарын 26	18,673,491
Зээлийн гэрчилгээ №18	2017 оны 4 сарын 13	24,719,970
Зээлийн гэрчилгээ №19	2017 оны 6 сарын 14	24,276,738
Зээлийн гэрчилгээ №20	2017 оны 7 сарын 14	24,126,779
Зээлийн гэрчилгээ №21	2017 оны 10 сарын 20	9,455,405
Зээлийн гэрчилгээ №22	2017 оны 11 сарын 14	9,406,080
Зээлийн гэрчилгээ №23	2017 оны 12 сарын 14	42,061,614
Зээлийн гэрчилгээ №24	2018 оны 1 сарын 12	51,091,188
Зээлийн гэрчилгээ №25	2018 оны 2 сарын 12	29,987,034
Зээлийн гэрчилгээ №26	2018 оны 4 сарын 12	139,134,556
Зээлийн гэрчилгээ №27	2018 оны 5 сарын 11	13,659,697



Зээлийн гэрчилгээ №28	2018 оны 6 сарын 13	27,135,133
Зээлийн гэрчилгээ №29	2018 оны 10 сарын 11	40,387,994
Зээлийн гэрчилгээ №30	2018 оны 11 сарын 13	47,988,766
Зээлийн гэрчилгээ №31	2019 оны 1 сарын 11	21,644,093
Зээлийн гэрчилгээ №32	2019 оны 2 сарын 13	59,754,329
Зээлийн гэрчилгээ №33	2019 оны 4 сарын 11	12,701,054
Зээлийн гэрчилгээ №34	2019 оны 5 сарын 13	35,484,091
Зээлийн гэрчилгээ №35	2019 оны 6 сарын 14	4,142,562
Зээлийн гэрчилгээ №36	2019 оны 7 сарын 12	14,386,961
Зээлийн гэрчилгээ №37	2019 оны 8 сарын 13	51,039,254
Зээлийн гэрчилгээ №38	2019 оны 9 сарын 13	16,210,824
Зээлийн гэрчилгээ №39	2019 оны 10 сарын 11	2,011,585
Зээлийн гэрчилгээ №40	2019 оны 12 сарын 13	55,959,239
Зээлийн гэрчилгээ №41	2020 оны 2 сарын 14	13,789,469
Зээлийн гэрчилгээ №42	2020 оны 3 сарын 12	25,248,023
Зээлийн гэрчилгээ №43.1	2020 оны 4 сарын 13	28,956,059
Зээлийн гэрчилгээ №43.2	2020 оны 4 сарын 14	8,472,625
Зээлийн гэрчилгээ №44	2020 оны 5 сарын 13	16,443,333
Зээлийн гэрчилгээ №45	2020 оны 7 сарын 14	19,047,626
Зээлийн гэрчилгээ №46	2020 оны 10 сарын 14	13,164,268
Зээлийн гэрчилгээ №47	2020 оны 12 сарын 14	25,890,879
Зээлийн гэрчилгээ №48	2021 оны 1 сарын 14	16,461,472
Зээлийн гэрчилгээ №49	2021 оны 2 сарын 12	7,275,254
Зээлийн гэрчилгээ №50	2021 оны 3 сарын 3	3,618,640
Нийт Санхүүжүүлсэн дүн	2,363,002,090 ам.доллар	

Оюу Толгой Нидерланд Би.Ви.-ийн нэрийн өмнөөс

Хүлээн зөвшөөрсөн:

Бид энэхүү Батламжийг хүлээн авснаа үүгээр хүлээн зөвшөөрч мөн дээр дурдсан Үлдэгдэл төлбөрийг баталгаажуулж байна.

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн нэрийн өмнөөс